

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Цэнджав	Дугаар	L134
Оршин суугаа аймаг	Сүхбаатар	Оршин суугаа сум	Наран
Төрсөн газар		Төрсөн он	1929
Ажил мэргэжил	Өндөр настан		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Их булгийн сүм	Сүм хийдийн дугаар	СБОН 014
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-р сарын 28	Ярилцлага авсан хүн	Ж.Одгарьд



Сүхбаатар аймгийн Онгон сумын Их булгийн сүм

-Танай нутаг оронд 1937, 38 оноос өмнө ямар ямар хийдүүд байсан бэ?

Сүм хийд бол их олон байсан шүү дээ. Молцогийн хийд, Овоон сүм гээд байсан. Манай Наранд Гүн худагийн хийд, Талын модонгийн хийд гэж байсан.

-Сайн худаг, Сөдөтийн хийд гэж тэмдэглэгдсэн байна?

Тийм. Одоо энд Сөдөтийн гэж бас нэг овгор шороо л байна шүү дээ. Ер нь сүм бол энүүгээр олон байсан юм гэнэ лээ.

-Энэ нэр дурдсан хийдүүдээс өөр ямар хийд байсан бол?

Хүнт цагаан нуурын тэнд нэг хийд байсан юм шиг байна лээ. Нэг ором байдаг юм.

-Та энэ хийдүүдээс өөрийн мэдэхийгээ арай дэлгэрэнгүй хэлж өгвөл сайн байна?

Молцог гэж энд харагдаж байгаа элс. Би ч одоо тахиж байдаг юм. Олон ламтай байсан юм гэсэн. Би одоо 78-тай. Би ч өөрөө сайн мэдэхгүй л байна.

-Сонссон дуулсан зүйл байвал? Өөрийн нутаглаж байсан газар оронтой аль хийд нь ойролцоо байсан гээд яривал?

Би ч одоо Онгонд ч байсан. Энэ Дарьгангад ч байсан. Ер нь одоо энэ хавиар л нутаглаж байсан л даа.

МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Их булгийн сүм гэж Онгон сумд одоо орох нэг хийд байсан. Тэнд би ааваараа дүүрүүлж нэг ламд очоод тэр хийдэд ламд шавь орж

байсан тэр лам шоо хаячихаад энийг лам болго, сайн лам болох юм байна гэж байсан юм гэнэ лээ. Шоголтой ном хулсан үзэгтэй. Багш хэдэн юм бичиж өгнө тэрийг бичиж чаддаг болоод байгаарай гэж хэлсэн. Тэгээд ааваараа дүүрүүлээд л явна. Тэгж бараг 2 сар явсан. Тэрнээс хойш удаагүй орчмын дараа сүмийг тарааж лам нар нь хөдөө гараад хар болцгоогоод байхгүй болсон. Их л том сүм байсан. Би Молцогийн сүмд л тэгж ойр байж очиж байсан юм даа.

-Молцогийн сүм хэдэн дугантай хэр олон ламтай хийд байсан бэ?

Лам нь чухам хэд байсныг мэдэхгүй. Их л том сүм байсан. Молцогийн

,Талын модонгийн, Гүн худгийн сүмүүдийг татан буугдахад бүрхныг нь үхэр тэргээр тээгээд Их булгийн сүмд аваачиж байсан юм гэнэ лээ.

-Хийд татан буугдаж балрах үед үү?

Тийм. Хийдүүд татан буугдаад. Сүмийг чинь түргэн байхгүй болгочихсон юм шүү дээ. Лам нар нь айгаад, дандаа хөдөө гараад, дандаа хар болоод. Лам захтай дээл өмсөхөө байж, хар хүний дээл өмсдөг болсон юм.

-Их булгийн сүм хэр том хийд байсан бэ?

Том байсан. Сүм нь гадуураа чулуун хороотой тийм л сүм байсан юм. Зүүн хойшоо гурвалжин модон дээр гурилаар балин хийгээд олон лам нар өргөөд чулуугаар барьсан дугариг зуухархуу юм байсан тэндээ аваачаад асааж үзнэ. Их удаан асна. Шар тос хийнэ. Тэгж байхыг нь бид нар үзэж байсан юм аа. Тэр нь сор залах байсан юм байна лээ.

Орхимжтой лам нар тойрч сууж байгаад ном уншина. Шатаж дуустал нь уншина. Тэр үед ч ямар шил гэж байсан биш, суулга саванд ус наалдуулж хөлдөөгөөд хөлдөөгүй хэсгийг нь асгаад суулганаас ховхолж аваад зулан дээрээ тавьж зулаа далдирахаас хамгаалдаг байсан. Тийм л байсан юм л даа. Надад бол мэдээд байх юм байхгүй.

-Их булгийн хийдийн төвд нэр нь юу гэдэг байсан бэ?

Их булгийн хийд л гэдэг шүү дээ. Хувилгаан багш гэж нэг багш байсан. Одоогоор бол хамба лам нь байсан. 3 гэр эгнүүлж барьсан гадуураа чулуугаар тойруулж барьсан хашаатай, халуун ханзтай тийм гэрт амьдардаг байсан. Халуун гэж жигтэйхэн. Анх хувилгаан багшийнх руу ороод цай идээ амсаад багш намайг наашаа суу гэсэн номоо сурсан уу гэсэн, сурсан гэсэн байсан даа. Өөр бол дэлгэрэнгүй мэдэх юм байхгүй.

-1990 он гарснаар Наран сумд шинэ сүм хийд сэргээгдсэн үү?

Байхгүй ээ.